

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/90-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn</p> <p>Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас:7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14-15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15-16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16-17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18-20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.08.28 № СЭА-2022/90-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МУЗЕЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М. БАЯРБААТАР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>39,561,700.00</u>	<u>38,341,120.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	39,561,700.00	38,341,120.00
354	Хангамжийн материал	39,561,700.00	38,341,120.00
35410	Бичиг хэргийн материал	1,345,100.00	3,172,120.00
35420	Аж ахуйн материал	38,167,600.00	34,825,800.00
35450	Барилгын засварын материал	-	343,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,423,505,641.20</u>	<u>3,469,657,923.41</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,423,505,641.20	3,469,657,923.41
392	Биет хөрөнгө	3,252,046,041.20	3,297,904,983.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,246,731,834.00	1,246,731,834.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,151,205.04)	(96,594,257.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,000,000.00)	(13,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57,894,995.75	52,772,134.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,172,480.96)	(15,954,771.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,612,161.00	37,143,366.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,394,793.20)	(13,243,752.68)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,972,205,910.00	2,016,104,410.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,097,911.41	55,097,911.41
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,778,291.76)	(11,151,890.24)
393	Биет бус хөрөнгө	171,459,600.00	171,752,940.00
39301	Програм хангамж	833,340.00	833,340.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(653,340.00)	(360,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	171,279,600.00	171,279,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,463,067,341.20</u>	<u>3,507,999,043.41</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,463,067,341.20</u>	<u>3,507,999,043.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,463,067,341.20	3,507,999,043.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	565,461,267.00	565,461,267.00
51101	Өмч: - төрийн	565,461,267.00	565,461,267.00
512	Хуримтлагдсан үр дүн	80,398,707.15	125,330,409.36
51210	Өмнөх үеийн үр дүн	80,398,707.15	80,398,707.15
51220	Тайлант үеийн үр дүн	-	44,931,702.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,817,207,367.05	2,817,207,367.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,463,067,341.20</u>	<u>3,507,999,043.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	569,798,701.30	309,224,861.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	347,758,400.00	99,673,863.00
120	Нийтлэг татварын бус орлого	347,758,400.00	99,673,863.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	347,758,400.00	99,673,863.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	222,040,301.30	209,550,998.78
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	667,500.00	2,597,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	667,500.00	2,597,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	221,372,801.30	206,953,498.78
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	221,372,801.30	206,953,498.78
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	242,371,044.84	263,903,408.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,371,044.84	263,903,408.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,721,544.84	261,393,408.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116,867,603.48	129,780,650.01
210101	Үндсэн цалин	83,119,454.42	101,089,338.53
210102	Нэмэгдэл	29,570,862.06	24,479,311.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,177,287.00	4,212,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,144,293.82	16,295,140.77
210201	Тэтгэврийн даатгал	9,622,809.48	11,636,985.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,140,997.99	1,294,316.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	988,471.10	1,035,453.40
210204	Ажилгүйдлийн даатгал	214,412.72	200,343.75
210205	Эрүүл мэндийн даатгал	2,177,602.53	2,128,041.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,987,804.00	26,499,200.00
210301	Гэрэл, цахилгаан	12,726,959.00	1,836,866.00
210302	Түлш, халаалт	6,524,753.00	24,004,619.00
210303	Цэвэр, бохир ус	2,736,092.00	657,715.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,169,365.00	18,277,880.00
210401	Бичиг хэрэг	1,420,540.00	2,083,760.00
210402	Тээвэр, шатахуун	636,300.00	1,160,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,520.00	905,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,182,000.00	950,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,904,550.00	3,400,320.00
210408	Бараа материал акталсны зардал	4,225,455.00	9,777,400.00
2105	Нормативт зардал	626,200.00	1,425,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	626,200.00	1,425,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,050,000.00	8,766,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	550,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	8,516,700.00
2107	Томилолт, зочны зардал	-	184,300.00
210702	Дотоод албан томилолт	-	184,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,751,630.00	7,232,508.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,319,630.00	7,232,508.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,124,648.54	52,931,830.02
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,124,648.54	52,931,830.02

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,649,500.00	2,510,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,649,500.00	2,510,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,157,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,492,000.00	2,510,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>327,427,656.46</u>	<u>45,321,452.98</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	389,750.77
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	389,750.77
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(389,750.77)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>327,427,656.46</u>	<u>44,931,702.21</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>222,040,301.30</u>	<u>209,550,998.78</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	222,040,301.30	209,550,998.78
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	667,500.00	2,597,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	667,500.00	2,597,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	221,372,801.30	206,953,498.78
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	221,372,801.30	206,953,498.78
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>205,290,401.30</u>	<u>209,550,998.78</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	205,290,401.30	209,550,998.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	175,640,901.30	207,040,998.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116,867,603.48	129,780,649.99
210101	Үндсэн цалин	83,119,454.42	95,028,802.60
210102	Нэмэгдэл	29,570,862.06	29,399,847.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,177,287.00	5,352,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,144,293.82	16,295,140.79
210201	Тэтгэврийн даатгал	9,622,809.48	11,636,985.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,140,997.99	1,294,316.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	988,471.10	1,035,453.40
210204	Ажилгүйдлийн даатгал	214,412.72	200,343.75
210205	Эрүүл мэндийн даатгал	2,177,602.53	2,128,041.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,987,804.00	26,499,200.00
210301	Гэрэл, цахилгаан	12,726,959.00	1,836,866.00
210302	Түлш, халаалт	6,524,753.00	24,004,619.00
210303	Цэвэр, бохир ус	2,736,092.00	657,715.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,078,020.00	14,261,800.00
210401	Бичиг хэрэг	1,459,200.00	2,603,980.00
210402	Тээвэр, шатахуун	636,300.00	1,160,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,520.00	905,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,182,000.00	950,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.00	8,641,420.00
2105	Нормативт зардал	2,503,200.00	1,425,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,503,200.00	1,425,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,050,000.00	9,249,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	550,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	8,999,900.00
2107	Томилолт, зочны зардал	-	184,300.00
210702	Дотоод албан томилолт	-	184,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,009,980.00	9,344,808.00

Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,423,000.00	9,344,808.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	154,980.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,649,500.00	2,510,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,649,500.00	2,510,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,157,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,492,000.00	2,510,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>16,749,900.00</u>	<u>-</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,749,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,749,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	16,749,900.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,749,900.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(16,749,900.00)</u>	<u>-</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	394,181,667.00	2,923,920,738.00	(216,463,779.38)	3,101,638,625.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	394,181,667.00	2,923,920,738.00	(216,463,779.38)	3,101,638,625.62
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	5,861,287.63	5,861,287.63
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	565,461,267.00	2,817,207,367.05	80,398,707.15	3,463,067,341.20
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	565,461,267.00	2,817,207,367.05	80,398,707.15	3,463,067,341.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	565,461,267.00	2,817,207,367.05	80,398,707.15	3,463,067,341.20
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	44,931,702.21	44,931,702.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	565,461,267.00	2,817,207,367.05	125,330,409.36	3,507,999,043.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,324,800.00	206,953,498.78	8,371,301.22	96.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,324,800.00	206,953,498.78	8,371,301.22	96.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	214,324,800.00	205,953,498.78	8,371,301.22	96.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,695,900.00	129,780,649.99	5,915,250.01	95.64
210101	Үндсэн цалин	102,728,400.00	95,028,802.60	7,699,597.40	92.50
210102	Нэмэгдэл	26,415,500.00	29,399,847.39	(2,984,347.39)	111.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,552,000.00	5,352,000.00	1,200,000.00	81.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,318,900.00	16,295,140.79	2,023,759.21	88.95
210201	Тэтгэврийн даатгал	12,891,100.00	11,636,985.39	1,254,114.61	90.27
210202	Тэтгэмжийн даатгал	1,357,000.00	1,294,316.69	62,683.31	95.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,085,600.00	1,035,453.40	50,146.60	95.38
210204	Ажилгүйдлийн даатгал	271,400.00	200,343.75	71,056.25	73.82
210205	Эрүүл мэндийн даатгал	2,713,800.00	2,128,041.56	585,758.44	78.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,499,200.00	26,499,200.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	5,432,600.00	1,836,866.00	3,595,734.00	33.81
210302	Түлш, халаалт	19,539,000.00	24,004,619.00	(4,465,619.00)	122.85
210303	Цэвэр, бохир ус	1,527,600.00	657,715.00	869,885.00	43.06
2104	Хангамж, бараа материалын зардал	13,174,300.00	13,174,300.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	948,000.00	1,516,480.00	(568,480.00)	159.97
210402	Тээвэр, шатахуун	546,300.00	1,160,800.00	(614,500.00)	212.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840,000.00	905,600.00	(65,600.00)	107.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,400,000.00	950,000.00	450,000.00	67.86
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,440,000.00	8,641,420.00	798,580.00	91.54
2105	Нормативт зардал	1,425,200.00	1,425,200.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,425,200.00	1,425,200.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,250,000.00	9,249,900.00	100.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	250,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	9,000,000.00	8,999,900.00	100.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	184,300.00	184,300.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	184,300.00	184,300.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,777,000.00	9,344,808.00	432,192.00	95.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,345,000.00	9,344,808.00	192.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	214,948,800.00	209,461,000.00	5,487,800.00	97.45
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	214,948,800.00	209,461,000.00	5,487,800.00	97.45
132001	Орон нутгийн төсвөөс	214,948,800.00	209,461,000.00	5,487,800.00	97.45

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,597,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,597,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,087,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,087,500.00
210401	Бичиг хэрэг	1,087,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,510,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,510,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,510,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,597,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,597,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,597,500.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музейн /цаашид Нэгдсэн музей гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримт, анхан шатны баримтын бүрдэл, хөтлөлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нэгдсэн музей нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Нэгдсэн музейн эрхэм зорилго нь “Ардын хувьсгалын өлгий нутгийн түүх, соёлын нандин өвийг хадгалж, хамгаалж, түгээн дэлгэрүүлэх”-д оршино.

Нэгдсэн музей нь “Музей, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах” гэж үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сэлэнгийн долгио чуулгын мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус Нэгдсэн музейн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 242,371.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,423.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 1,696.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нэгдсэн музейн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,931.7 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	39,561.7	38,341.1	(1,220.6)
Үндсэн хөрөнгө	3,423,505.6	3,469,657.9	46,152.3
Нийт хөрөнгө	3,463,067.3	3,507,999.0	44,931.7
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,463,067.3	3,507,999.0	44,931.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,463,067.3	3,507,999.0	44,931.7

Бараа материалын дансны үлдэгдэл 38,341.1 мянган төгрөг болж 1,220.6 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн Онцгой комиссоос 200.0 мянган төгрөгийн халуун хэмжигчийг үнэ төлбөргүй хүлээн авсан болон төсвийн хөрөнгөөр 28,803.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 27,793.9 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсан, 2,430.0 мянган төгрөгийн материалыг акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,619,962.6 мянган төгрөг болж өмнөх оноос 32,306.8 мянган төгрөгөөр өссөн нь 43,898.5 мянган төгрөгийн түүхийн эд өлгийн зүйлийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХТ-ийн тогтоолоор 11,591.7 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж акталж, устгаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,507,999.0 мянган төгрөг болж, 44,931.7 мянган төгрөгөөр өссөн нь нийт хөрөнгө өссөнөөс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 260,573.8 мянган төгрөгөөр буюу 45.7 хувиар буурсан нь тусламж санхүүжилтийн орлого болон өөрийн орлого буурснаас голлон шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 21,532.4 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн нь нормативт зардал болон элэгдлийн зардлууд материаллаг хэмжээгээр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг тус бүр 315,592.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд

шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 100,267.7 мянган төгрөгөөр бууруулж, 215,324.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь урсгал засварын зардлыг 48,479.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 51,788.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталснаас голлон шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр **215,324.8** мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 206,953.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 206,953.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **206,953.5** мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үйл ажиллагааны орлогоос 2,597.5 мянган төгрөг бүрдүүлж, бичиг хэргийн зардалд 1,087.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 1,510.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан ажилласан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон М.Баярбаатарыг Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны Б/30 дугаар захирамжаар тус музейн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон нь Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Улсын болон бүс нутгийн, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн соёлын байгууллагын дарга, захирлыг тухайн салбарын мэргэжилтэй, соёл, урлагийн байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 25.1, 27.1.1, 27.2, 27.3-т заасны дагуу **сонгон шалгаруулж томилно**” гэж заасныг зөрчсөн байна. Иймд ажлын байрны сонгон шалгаруулалтыг явуулсны үндсэн дээр удирдах албан тушаалтныг томилж байх нь зүйтэй юм.

3.7.2 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” болсон 304,634.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 154 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж

байгаа учир цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Нэгдсэн музей нь мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс дараах 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт,
- Байгууллагын батлагдсан төсөв,
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Нэгдсэн музейн тайлант оны үйл ажиллагаанд 215,324.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 206,953.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 3.9 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулах зөвлөмж өгөгдсөнийг биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	1	-	1	-	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан шалгагдагч байгууллагын эд хөрөнгийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19,227.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,607.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 17,620.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 4 зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага:

1. Үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас гэрээт ажилтны цалинд 1,607.4 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

4.2 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс үндсэн хөрөнгө, багаж, тоног төхөөрөмж худалдан авахад 5,472.0 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

2. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”- аар баталгаажуулж, бүртгээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.4-ыг зөрчиж байгаа бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул илүү цагийн хөлсийг “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”- аар баталгаажуулж, бүртгэж байх.

3. Шилэн дансны мэдээлэлттэй холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

4. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

4.1. Илрүүлэлт: Тайлант онд 12,148.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ*” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музей	5	19,227.8	-	-	-	-	1	1,607.4	4	17,620.4